



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2017.11.06 № 4-1/6303

танай _____-ны № _____-т

2017 оны төсвийн тодотгол
хүргүүлэх тухай

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд Улсын Их Хурлын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлагдлаа. Орон нутгийн 2017 оны тодотгосон төсвийн тооцоолол болон орон нутгийн тодотгосон төсөв боловсруулж, батлуулахад баримтлах зарчмыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт №1. Орон нутгийн 2017 оны тодотгосон төсөв боловсруулж, батлуулахад баримтлах зарчим

Хавсралт №2. Орон нутгийн 2017 оны санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн тооцоо

Хавсралт №3. 2017 оны орон нутгийн төсвийн суурь орлого

Хавсралт №4. 2017 оны орон нутгийн төсвийн суурь зарлага

Хавсралт №5. 2017 онд улсын төсвөөс орон нутгийн төсөвт шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг

Хавсралт №6. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2017 онд сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал

Орон нутгийн 2017 оны төсвийн тодотголын дэлгэрэнгүй тоо, мэдээллийг Төсвийн ил тод байдлын www.iltod.gov.mn сайтад байршуулсан болно. Монгол Улсын 2017 оны тодотгосон төсвийн дагуу орон нутгийн төсвийн тодотголыг хийж, төсвийн хуваарийг шинэчлэн баталж ирүүлэх, УИХ-аас гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг Төсвийн тухай хуулийн дагуу зохион байгуулахыг хүсье.

Хүндэтгэсэн



Ч.ХҮРЭЛБААТАР